



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/74

Мандалговь

Орчны цэвэрлэгээ, ариутгал хорогдсон
мал, амьтны сэг зэмийг цуглуулж
устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/47 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булаг, орон нутгийн төв замын дагуу болон өвөлжөө, хаваржааны цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх, харьяалах нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, булж устгах ажлыг 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Орчны цэвэрлэгээ, ариутгал хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Гадны аймаг, сумдад оторлож байгаа малчид орон нутаг руугаа нүүдэл хийхдээ хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэл хийх, төлөвлөгөө гаргаж, ажлыг зохион байгуулахад шаардагдах зардалд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Мэргэжил аргагүй удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), үр дүн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210203